



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 4/173

Номгон


Бэлэн бусаар торгох машин болон дундаж  
хурдны системийн эрх сунгахад хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Замын цагдаагийн тасгийн албан хэрэгцээний бэлэн бусаар торгууль ногдуулах 18 машин, Хяналтын 2 цэгт байрлах дундаж хурдны системийн дата симийн хугацааг сунгах зардалд 3,060,000.0 (Гурван сая жаран мянган төгрөг)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Бэлэн бусаар торгуулсан иргэд торгуулиа төсөвт төвлөрүүлэхгүй байгаа тул уг торгуулийг төсөвт төвлөрүүлэхэд анхаарч арга хэмжээ авч ажиллахыг Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642310425